



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2014 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/148

Улаанбаатар хот

Гадна хаяг, мэдээллийн байгууламжид  
тавигдах шаардлага батлах тухай

Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Монгол хэл, бичгийн боловсролын сайжруулах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоолын 5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 3/32 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулахад дагаж мөрдөх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.4.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар бүлгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна хаяг, мэдээллийн байгууламжид тавигдах шаардлагыг хавсралтаар баталсугай.


2. Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна хаяг, мэдээллийн байгууламжид тавигдах шаардлагыг хангуулах, түүнд хяналт тавьж ажиллахыг Дүүргүүдийн Засаг дарга нар, Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Т.Батбаяр/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА

Б.БАДРАЛ

УХА0501 9077367

1110300487



## ГАДНА ХАЯГ, МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

### Нэг. НИЙТЛЭГ ШААРДЛАГА

- 1.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна хаяг, мэдээллийн байгууламж нь гадна зар сурталчилгааны нэгэн төрөл болох ба Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 3/32 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламжийг байрлуулахад дагаж мөрдөх журам"-д заагдсан гадна зар сурталчилгааны байгууламжид тавигдах шаардлагыг хангасан байна.
- 1.2 Гадна хаяг, мэдээллийн байгууламжийг хот төлөвлөлт, хотын архитектурын шийдэл, иргэдийн болон авто замын хөдөлгөөний аюулгүй байдал, хэл бичгийн стандарт, шаардлагад нийцүүлэн барилгын хана, гудамж, талбай болон бусад орон зайд байрлуулах, буулгах, ашиглахад энэхүү тавигдах шаардлагыг үндэслэл болгоно.
- 1.3 Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2013 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/170 тушаалаар батлагдсан "Гадна зар сурталчилгааны байгууламжид тавигдах тусгай шаардлага"-ыг хангасан байна.
- 1.4 Гадна хаяг, мэдээллийн байгууламжийн бичвэрийг Монгол Улсын засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 5 дахь заалтын дагуу Монгол хэл /крилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих ба Монгол бичиг /уйгаржин/-ээр бичиж болно.
- 1.5 Шаардлагатай нөхцөл /бараа, бүтээгдэхүүний нэр, лого нь зохиогчийн эрхээр баталгаажсан, гадаадын иргэд олноор үйлчлүүлдэг/-д гадна хаяг, мэдээллийн байгууламжийн бичвэрийг англи хэлээр бичих ба бичвэр нь монгол бичвэрийн доод талд байрлаж, түүнээс 2 дахин бага өндөртэй байх эсвэл монгол /крилл/ бичвэрийн зүүн гар талд байрлаж, түүнтэй ижил өндөртэй байна.

### Хоёр. ОРОН ЗАЙН ШААРДЛАГА

- 2.1 Гадна хаяг, мэдээллийн байгууламжийг өөрийн барилга объектын хана, дээвэрт байрлуулах боломжгүй эсвэл тухайн байгууллагын байршил нь олон нийтэд үзэгдэх орчин хязгаарлагдмал байдлын улмаас нийтийн эзэмшлийн гудамж, талбайд хаяг, мэдээллийн байгууламжаа байрлуулах шаардлагатай нөхцөлд тухайн нутаг дэвсгэрийн харьяалагдах дүүргийн Засаг даргын тамгын газраас зөвшөөрөл авна.
- 2.2 Гадна хаяг, мэдээллийн байгууламжийг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулах нөхцөлд дараах хэм хэмжээг баримтална.



- 2.2.1 Автомашин болон явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүй, үзэгдэх орчин хязгаарлахгүй байх
  - 2.2.2 Замын байгууламжаас 1 метрээс багагүй зайд байрлана. /Зураг №01/
  - 2.2.3 Авто зам, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэхээр төлөвлөж байгаа газарт байрлуулахгүй байх.
- 2.3 Гадна хаяг, мэдээллийн байгууламжийг барилгын хана, фасад дээвэрт байрлах нөхцөлд тухайн барилга болон хөрш зэргэлдээ объектын цонх, хаалга, үзэгдэх орчинг халхлахгүй байна.

#### Гурав. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА


- 3.1 Гадна хаяг, мэдээллийн байгууламж нь гадна эсвэл дотор гэрэлтүүлэгтэй байна.
- 3.2 Цахилгаан болон барилга угсралтын аюулгүй ажиллагааны талаарх холбогдох норм, стандартыг баримталсан байна.
- 3.3 Гадна хаяг, мэдээллийг байгууламжийг байрлуулах барилгын даац, гадна фасадны бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байхын зэрэгцээ хууль ёсны эзэмшигч, ашиглагч нараас албан ёсоор зөвшөөрөл авсан байна.
- 3.4 Нэг барилга, объектэд хэд хэдэн байгууллага, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд тэдгээрийн гадна хаяг, мэдээллийн байгууламж нь дараах шаардлагыг хангасан байна.
  - 3.4.1 Нэг барилга байгууламжид байрлаж буй хэд хэдэн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна хаяг, мэдээллийн байгууламжийн нийт овор хэмжээ нь жигд өндөрт байрлаж, ижил өнгийн дэвсгэр дээр хийгдэх ба лого болон бичвэрийг тус тусын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн байрлуулна. /Зураг №02/
  - 3.4.2 Нэг барилгад үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн байгууллагын гадна хаяг, мэдээллийн байгууламжийг нийтийн эзэмшлийн талбайд байрлуулахаар бол бүх байгууллагын мэдээллийг агуулсан нэгдсэн мэдээллийн байгууламжийг тухайн барилгын эзэмшигч, өмчлөгчийн зүгээс байрлуулна. /Зураг №03/
  - 3.4.3 Аль нэг байгууллага солигдох, мэдээлэл нь шинэчлэх үед мэдээллийг хялбар өөрчилж болох шийдэлтэй байна.
- 3.5 Гадна хаяг, мэдээллийн байгууламж нь хотын өнгө үзэмжид нийцсэн, орчин үеийн технологийн шийдлийг ашигласан байхаас ба засвар, үйлчилгээг тогтмол хийж, бүрэн бүтэн байдлыг хангуулна.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ДЭРГЭДЭХ  
ГАДНА СУРТАЛЧИЛГААНЫ ЗӨВЛӨЛ

ХАВСРАЛТ ЗУРАГ



ЗУРАГ № 01



Тайлбар:  
Их тойруугийн ....

ЗУРАГ № 02





Зураг № 03